



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 09 сарын 24 өдөр

Дугаар А/599

Булган сум

Пүрэвжавын Оюунцэцэгт тусламж үзүүлэх
эрх олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1.3 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.4 дэх хэсэг, 61 дүгээр зүйлийн 61.1.1 дэх заалт, Хөдөлмөрийн тухай хуулийн 122 дугаар зүйлийн 122.1 дэх хэсэг, Эрүүл мэндийн газрын даргын 2025 оны А/48 дугаар тушаалаар баталсан байгууллагын “Хөдөлмөрийн дотоод журам”-ын 6.2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Эрүүл мэндийн газрын дарга Пүрэвжавын Оюунцэцэгийн нөхөр хүнд өвчний улмаас таалал төгссөн тул Эрүүл мэндийн газрын дотоод журамд заасны дагуу тусламж олгосугай.

2. Буцалтгүй тусламжид шаардлагатай хөрөнгийг Эрүүл мэндийн газрын зохих төсвөөс гаргахыг нягтлан бодогч (И.Энхжаргал)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Д. ПҮРЭВ-ОЧИР